



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.07 № 01/788
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ САРАНГЭРЭЛИЙН
ПҮРЭВДОРЖ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Сарангэрэлийн Пүрэвдоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Сарангэрэлийн Пүрэвдоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Сарангэрэлийн Пүрэвдоржийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Сарангэрэлийн Пүрэвдоржд

Хувийг: Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Сонгуулийн хороонд

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР


ХӨВСГӨЛ АЙМГИЙН БҮРЭНТОГТОХ СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД ИХ-УУЛ БАГТ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ САРАНГЭРЭЛИЙН ПҮРЭВДОРЖ МИНИЙ
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

НЭГ: ЗОРИЛТ

- Сум орон нутгийн хөгжил дэвшилд өөрийн саналаа тусгуулан ИТХ-ын шийдвэр гаргуулахын төлөө, иргэдээ төлөөлөн идэвх санаачилагатай ажиллана.

ХОЁР: ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

- Үндэсний бахархал болсон ном судар, баримтат өвүүдийг нийтэд таниулан сурталчилан таниулах.
- Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэг үзүүлэх, боловсролд тэгш хамруулах.
- Эрүүл мэндийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн хүний нөөц, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулах, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлт, албан бус хөдөлмөр эрхлэлтийг бүртгэлжүүлэх



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН: *C. Пурм* /С.ПҮРЭВДОРЖ/

00000001